

## Тропикийн циклон ба Хар салхи

Нислэгийн цаг уурын төвөөс хамтран ажилладаг авиакомпаниуддаа сэрэмжлүүлэх үүднээс дараах мэдээллийг оруулж байна. Сүүлийн үед бидний нисэн очдог олон улсын нисэх буудлуудад /Чезү арал, Пусан, Нарита..... гэх мэт/ хар салхи болох давтагдал ихсэж байгаа тул та бүхэн доорх мэдээлэлтэй танилцан үйл ажиллагаагаа төлөвлөнө үү.



Тропикийн циклон буюу Хар салхи нь төв хэсэгтээ агаарын нам даралттай, аадар бороо бүхий цаг уурын нэгэн төрлийн үзэгдэл болно. "Циклон" гэдэг үг нь цагираг хэлбэрийн эргүүлгийг хэлэх бөгөөд

уг эргүүлэг Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст, цагийн зүүний эсрэг чиглэлтэй байна. Бүх тропикийн циклонууд тропик орчмын харьцангуй дулаан далайд үүсэх ба хүчтэй салхи, ширүүн бороо үүсгэнэ. Зарим тропикийн циклонууд эх газрыг дайрч болох бөгөөд энэ тохиолдолд асар их хэмжээний хохирол учруулдаг байна. Үүсэх салхины хурдаар нь:

- Тропикийн циклон: Салхины хурд хамгийн ихдээ 33 үзел (17м/с, 61 км/ц,) байна.
- Тропикийн шуурга: Салхины хурд хамгийн ихдээ 34-63 үзел (18-32м/с, 62-117км/ц) байна.
- Хар салхи: Салхины хурд 64 үзел (33м/с, 119 км/ц) буюу түүнээс их байна. Хойд Номхон далайн баруун эргээр болох хар салхийг тайфун гэх бөгөөд Энэтхэгийн далай, Өмнөд Номхон далайд тохиолдохыг циклон гэж нэрлэнэ /Зураг 1/.
- Их хар салхи: Салхины хурд 96 үзел (50м/с, 179км/ц) буюу түүнээс их байх бөгөөд хар салхины 3, 4, 5-р зэрэглэлд /хүснэгт 1/ хамаарна.

гэж ангилна.

Хар салхийг салхины хурд болон учруулах хохирлын хэмжээгээр нь 5 ангилалд хуваадаг. Saffir-Simpson –ий хар салхины ангиллыг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Сафир-Симпсоны хар салхины ангилал


Ангилал	Тогтвортой салхины хурд	Хар салхины учруулах хохирлын хэлбэр	Хар салхи
1	64- 82 үзел (119- 153км/ц, 33-43м/с)	Асар их аюултай салхи зарим хохирлыг учруулна.	Доли (2008) АНУ-ын Техасын өмнөд Падрегийн арал
2	83- 95 үзел (154- 177км/ц, 44-49м/с)	Дээд зэргийн аюултай салхи их хэмжээний хохирлыг учруулна.	Франсис (2004) Флоридагийн Санкт Лусиегийн эргийн боомт
3	96- 112үзел (178- 208км/ц, 50-58м/с)	Сүйрүүлсэн хохирол, гэмтлийг бий болгоно.	Иван (2004) Алабамагийн Шоресийн буланд
4	113- 136 үзел (209- 251км/ц, 59-70м/с)	Гамшигт аюулыг бий болгоно.	Чарли (2004) Флоридагийн Пунта Гордагийн эрэгт
5	>136 үзел (251км/ц, 70м/с)	Гамшигт аюулыг бий болгоно.	Эндрю (1992) Флоридагийн Катлер Хярын эргийн хэсэгт

Хар салхины улирал ба түүний хамгийн их тохиолдох саруудыг хүснэгт 2-т үзүүлэв.  
Хар салхины улирал ба түүний хамгийн их тохиолдох сарууд:

Хүснэгт 2.

Д/д	Байршил	Хугацаа [сар]	Хамгийн их үүсэх үе [сар]
1	Атлантын далай болон Карибийн тэнгис	06.01 – 11.30	8 сарын дундаас 10 сарын сүүл
2	Номхон далайн төв хэсэг (Хавай)	06.01 – 11.30	07 -09
3	Номхон далайн зүүн хэсэг	05.15-11.30	-
4	Хойд Номхон далайн баруун талд	Жилийн турш	-

Хар салхины газарзүйн нэршлийг Зураг 1-т үзүүлэв.



Зураг 1. Хар салхины газарзүйн нэршил

Ашигласан материал:

- Tropical cyclones, National Weather Service, National Oceanic and Atmospheric Administration
- [www.google/geographyworldmap](http://www.google/geographyworldmap)
- <http://geomtrx.com/cgb/hurricane-typhoon-cyclone-location-location-location/>

НЦУТ